



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

᠒᠐᠒᠒ оны ᠐᠘ сарын ᠒᠒ өдөр

Дугаар ᠑/᠒᠒

Мандалговь

“Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Дундговь”-ийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Дундговь”-ийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Н.Түвшинжаргал (Аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд:

Г.Мандах (Аймгийн Засаг даргын туслах)

Э.Энхжаргал (Иргэний төлөөлөл)

Э.Мөнхзол (Иргэний төлөөлөл)

Нарийн бичиг:

Ж.Гантулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)

2. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Н.Түвшинжаргал)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ж.Гантулга)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л. ДОРЖБАТ

4822150092